

БАТЛАВ  
 УВС АЙМГИЙН ЗАСАГ  
 ДАРГА
 
  
 Д.БАТСАЙХАН

**УЛААНГОМ СУМАНД БАЙГУУЛАГДАХ ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД УНДНЫ БОЛОН  
 ХАА-Н ЗОРИУЛАЛТААР ГАРГАХ ХУДАГ, УСАЛГААНЫ СИСТЕМ,  
 АЖЛЫН ДААЛГАВАР, ТАВИГДАХ ШААРДЛАГА  
 /УЛААНГОМЫН 5-Р БАГТ-2 ХУДАГ/**

1. Худаг шинээр барихаас өмнө хорооллын айл өрхийн байршил, нүхэн жорлон зэрэг хөрсний ус бохирдуулагч эх үүсвэрийг тогтоон худгийн эрүүл ахуйн онцгой хамгаалалтын бүс тогтоох боломжийг судалсан байна.
2. Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага **MNS 6088-2010** стандартын дагуу өрөмдлөг, шавхалт, туршилтын ажлыг явуулах, худгийн шахуурга, цахилгаан эрчим хүчинд холбох, худгийн усан сан барих ажлыг гүйцэтгэнэ.
3. Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 101/189/194 тоот хамтарсан тушаалаар баталсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ыг мөрдөнө. Үүнд:

Үзүүлэлтүүд	
<b>1.</b>	<b>Цооног өрөмдөх, цооногийг тоноглох</b>
1.1	Геофизикийн болон хуучин худгийн судалгаа хийж худгийн байршлыг БОАЖГ, аймаг, сумын ЗДТГ-тай хамтран тогтоож, цооног өрөмдөх зөвшөөрөл авсан байна.
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: Худгийн гүнээс хамаарч насосны хүчин чадлыг сонгох ба ундарга 0,6-2л/сек байна.
1.3	Худгийн өрөмдөх гүн 25м-ээс доошгүй байна.
1.4	Суултын яндангийн материал нь ган хоолой байна.
1.5	Шүүрийн яндангийн материал нь ган хоолой байна.
1.6	Ус өргөх яндангийн голч нь 25мм-ээс багагүй, материал нь ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой буюу зэвэрдэггүй ган хоолой байна. /хүйтний улиралд тэсвэртэй/
1.7	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9мм-ээс томгүй байна.
1.8	Шүүрийн урт нь уст үеийн зузаанаас хамаарч 3м-ээс багагүй, тунгаагуурын урт 2м-ээс багагүй байна.
1.9	Худгийн шавхалт хийж цооног цэвэршүүлэх хугацаа 48 цагаас багагүй байна.
1.10	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх ажлыг стандартын дагуу хийлгэсэн байна.
1.11	Худгийг түр хугацааны тагаар тоногловсон байна.
<b>2.</b>	<b>Худгийн барилга, усан сан, ус авах талбай барих</b>
2.1	Худгийн барилга: БНБД81-05-06, БНБД81-10-06, БНБД81-11-066, БНБД81-12-06, БНБД81-15-06-д заасан шаардлага хангасан байна. Худгийн барилгын өрөг нь "Өрөгт бүтээц" БНБД51-02-05, Дээврийн ажил нь "Дээврийн хучлага" БНБД31-02-03, Шал нь БНБД31-12-06 зэрэг барилгын норм, дүрмийг хангасан байна.

	<p>Хэмжээ /дотор талдаа/ 2,4х2,4м, ханын өндөр шалнаас дээш 2м</p> <ul style="list-style-type: none"> <li>• Материал: Тоосго</li> <li>• Ханын зузаан: 38см-аас багагүй.</li> <li>• Ханын дотор, гадна талыг шавардан цагаан өнгийн эмульсээр эмульсдэнэ. /Гадна талыг өнгөлгөөний тоосгоор хийсэн тохиолдолд шавардаж эмульсдэхгүй/</li> <li>• Худгийн дээр 30х30см хэмжээтэй нээлхийг цооногын чанх харалдаа дээд талд худгийг засварлахад тохируулан хийнэ.</li> <li>• Худгийн цонх нь 40х50см хэмжээтэй, онгойдог байх бөгөөд ус түгээх хоолойн харалдаа дээд талд байрлана. Хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна.</li> <li>• Дундаа 5см-ийн хөөсөнцөр дулаалгатай төмөр хаалгатай байна.</li> <li>• Худгийн барилга нь дулаан алдагдал багатай, ухаалаг худаг төхөөрөмж суурилуулах боломжийг бүрдүүлсэн байна.</li> </ul>
2.2	Ундны ус авах хоолойг давхар төлөвлөж өгөх ба хоолой нь 25 мм, 32 мм диаметртай ундны усанд хэрэглэхэд зориулсан ган хоолой байна. Уртыг ундны ус түгээхэд тохиромжтой байхаар сонгоно.
2.3	<p>Усан сан : Худаг 1- Босоо суурьтай тоноглогдсон, ундны усны зориулалтын 4,0м<sup>3</sup>-ээс багагүй багтаамжтай битүү усан сантай байна. Усан сан нь цэвэрлэгээ үйлчилгээ хийх боломжтой байх ба баруун Монголын соёлын өвийг хадгалсан Икэл хөгжмийн хэлбэртэй, гадна талыг нь хөгжмийн дүр зураг оруулж будсан, хажуу талд нь Икэл хуурын талаарх түүхийг монгол, орос, англи хэлээр, гаргацтай, хуурч унахгүй, бөх материалаар бичиж, тогтоосон байна.</p> <p>Худаг 2 - худгийн усан сан нь баруун монголын ээтэн гутлын хэлбэр, хээ зураг бүхий, босоо суурин дээр 4 м<sup>3</sup>-ээс багагүй багтаамжтай, битүү усан сантай байна. Ээтэн гутлын хэлбэрт усан сангийн хажуу талд нь гутлын талаарх түүхийг монгол, орос, англи хэлээр, гаргацтай, хуурч унахгүй, бөх материалаар бичиж, тогтоосон байна.</p>
2.4	БОНХАЖСайдын 2013 оны 05-р сарын 16-ны өдрийн А/156 тоот тушаалын дагуу ерөнхий шугамд усны тоолуур суурилуулна.
2.5	<p>Ус түгээх талбай:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Худгийн байшингаас 2 м-ийн зайд откос 1,5-2 налуутай байрлана.</li> <li>• 2х3м-ийн хэмжээтэй 10см зузаантай бетонон талбай барих бөгөөд асгарсан илүүдэл ус зайлуулах боломжтой сувагтай байна.</li> <li>• Материал: Цементийн марк 150-аас дээш портланд цемент байна.</li> <li>• Худгийн ус авах талбай нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.</li> <li>• Худгийн гадна болон дотор талд ерөнхий гэрэлтүүлэгтэй байна.</li> </ul>
2.5	<p>Усалгааны систем: Усан санд цуглуулсан усаар цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг услах ба усны хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологитой байна.</p> <p>3,2 га талбайд тарьсан /2140 м урт хашааны эргэн тойрон эгнээ хооронд 3 м зайтайгаар 2 эгнээ мод таригдана. /модыг услах боломж бүхий дуслын услалтын иж бүрэн систем байрлуулсан байх шаардлагатай.</p>
<b>3</b>	<b>Худгийн насос, цахилгааны эх үүсвэр, хянах самбар</b>
3.1	Гүний насос ISO 9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны ялангуяа Увс аймгийн эрс тэс уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой, тухайн худгийн гүн, суултын яндангийн диаметр, хэрэглэгчийн усны

	хэрэгцээнд тохируулан сонгоно. Насосыг зориулалтын троссоор бэхэлсэн байна.
3.2	Цахилгааны утас: 3 салаатай, ус чийгтэй орчинд ашиглах шаардлага хангасан, насосны хянах самбар хүртэл үргэлжилсэн (залгаасгүй), ус өргөх янданд 2м тутамд хавчин тогтоосон /туузаар ороохгүй/ байна.
3.3	Хянах самбар: Асаах, унтраах товчлууртай, насос ажиллаж буйг илэрхийлэх ногоон, хүчдэл буйг илэрхийлэх, улаан гэрлээр асах индикатортай, насос асаах асаагууртай байх.
3.4	Цахилгаан дамжуулах шугам нь гал түймрийн болон аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, газардуулгатай байна. Цахилгаанд холбоно.
<b>4</b>	<b>Худгийн ажлыг дуусгах, хүлээлгэн өгөх.</b>
4.1	Талбайг цэвэрлэсэн байна.
4.2	Худаг гүний насосыг ажиллуулж туршин акт үйлдэж, талбайн сургалт хийсэн байна.
4.3	Худгийн өрөмдлөг, цооногийн хийц, шавхалт, тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг MNS6088:2010 стандартын дагуу гүйцэтгэж баримтжуулан, худгийн паспорт хөтөлсөн байна.

Хянасан:  
Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга



Б.Бат-Ерөөлт

Боловсруулсан:  
Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтэн

Б.Энхтуяа